

**Монгол хэлний “адууны явдал” хэмээх
утгын орны зарим онцлог**

Гомбын ГЭРЭЛМАА*

*Монгол Улс, Улаанбаатар хот, Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль,
Ерөнхий эрдмийн тэнхим*

Received: 30 September 2025 / **Accepted:** 20 October 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй: Монголчуудын өнө эртнээс нааш эрхэлсээр ирсэн нүүдлийн аж ахуй нь байнгын хөдөлгөөнтэй, сэтгэл хөдлөлтэй, өөр өөрийн ааш авиртай амьд объект болсон мал амьтантай харьцдаг; тэдгээрийн зүс, гадаад төрх нь улирал, байгаль цаг уурын онцлогоос шалтгаалж хувирч өөрчлөгддөг; тэднийг эрэх хайх, зүслэх шаардлага зайлиггүй урган гардаг учраас нүүдэлчдээс ажигч гярхай чанарыг зүй ёсоор шаарддаг.

Иймээс нүүдэлчид өөрийн хотны хэдэн арваас эхлээд хэдэн зуун малыг өөр хооронд нь төдийгүй бусад айл, саахалтын малаас ялгахын тулд тэдний өнгө зүс, нас хүйс, авир араниш, явдал хөдөлгөөн зэрэг өвөрмөц шинжүүдийг ялган тогтоож малд нүдтэй болдог.

Ийнхүү монголчууд нь хэдэн мянган жилийн турш нүүдлийн аж ахуй эрхлэх явцаа мал маллах өвөрмөц арга ухаан, соёлыг цогцлоон хөгжүүлж, малынхаа тэрхүү нийтлэг болон өвөрмөц онцлог шинжийг нарийн танин мэдсэн мэдлэгээ монгол хэлэндээ шингээн хадгалсаар иржээ. Ингээж монгол хэлэнд нүүдлийн соёл, таван хошуу малтай холбоотой шаталсан шинжтэй олон арван утгын орон, тэдгээрийг бүрдүүлсэн үгийн сангийн баялаг нэрлэлтийг бий болгожээ.

Эдгээрээс бид малын явдал, тэр дундаас “адууны явдал” гэсэн утгын оронд хамаарах нэрлэлтийг монгол ардын оньсого, зүйр цэцэн үгийн өнгөн бүтцээс хөөн судлахад монголчууд адууны үндсэн явдлыг ерөнхийд нь 11 ангилж, тэдгээрийг дотор нь 50 гаруй янзаар ялгаж, дүрслэн нэрлэжээ.

Түлхүүр үгс: утгын орон, адууны явдал заасан үгс (алхах, шогших, хатирах, давхих гэх мэт)

**Some Features of the Semantic Field of
"Horse Gaits" in Mongolian Language**

GERELMAA Gombo

*Department of General Studies, International University of Ulaanbaatar,
Ulaanbaatar, Mongolia*

* © Го. Гэрэлмаа, 2025, Email: gerelmaa.g@ulaanbaatar.edu.mn



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

Abstract: While there are relatively few terms related to horse gaits in the hippology study, words with such characteristics are relatively abundant in the structure of Mongolian folk riddles and proverbs.

This is partly because the nomadic economy that Mongolians have been engaged in since ancient times involves constant interaction with livestock, which are living objects with their own unique behaviors, emotions, and temperaments. The appearance and physical characteristics of these animals change according to seasonal and climatic conditions, so it requires to be keen on observational skills to manage and care for their livestock from nomads.

Therefore, nomads develop the ability to distinguish their own hundreds of livestock from one another, as well as from those of other families, by identifying and naming their unique characteristics, such as color, age, sex, behavior, and movement patterns.

Thus, the Mongolian language has been developed with a extensive and nuanced vocabulary related to livestock, reflecting the importance of animal husbandry in Mongolian culture and daily life. By observing the structure of folk proverbs and riddles alone, we can see that Mongolians have categorized the basic movements of horses into 11 general categories, and within those categories, they have distinguished and described over 50 different variations, creating a semantic field that names and describes horse movements.

Key words: Semantic Field, Describes Horse Movements (Walk, Trot, Canter, Gallop ets)

1. Удиртгал

Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар тольд “Утгын орон (Semantic field, семантические поле) – утга, агуулгын ерөнхий шинжээрээ холбогдсон үгийн сангийн нэгжүүдийн олонлогийн шаталсан бүтэц. Ийм бүтцүүд тэмдэглэгдэж байгаа үзэгдлийн ухагдахууны, юмны, үүргийн адилшиг байдлыг тусгадаг. Утгын орон нь утгын ерөнхий шинжтэй хэлэнд ухагдахууны тодорхой хүрээг тусгадаг үгийн сангийн нэгжүүдийг багтаадаг. Жишээ нь, “Орон зайд хөдлөх” гэсэн утгын орон нь явах гүйх, давхих, нисэх, зүглэх, мордох, одох гэх мэт үйл үгсийг багтаана” (Зээнямбуу, Базаррагчаа, 2014: 390) гэж тайлбарлажээ.

Нүүдэлчин монголчууд өнө эртнээс адууг өсгөн үржүүлж, уналга эдэлгээнд сургах, тоног хэрэгсэл бэлтгэх, ашиг шимийг нь хүртэх явцдаа түүнийг адуулах арга технологийг боловсруулан, улмаар адууг тойрсон үндэсний өвөрмөц соёлын түүхийг бий болгож, адууныхаа үйл хөдлөл, өнгө зүс, авир араншин зэргийг зүйлчлэн нэрлэж, адуутай холбоотой утгын томоохон орныг бүрдүүлжээ. Тухайлбал, Эрдэмтэн Л.Мөнхтөр монгол ардын аман зохиолын 14 төрөл зүйлээс судалгаа хийгээд адууны үндсэн зүс 30 шахам, зүс тодруулан чимэх үгс 400 гаруй байна (2002: 35) гэж тэмдэглэжээ.

Бид энэ өгүүлэлдээ ардын зүйр цэцэн үг, оньсогойн өнгөн бүтцээс монгол хэлний адууны явдал заасан утгын орон түүнийг бүрдүүлж буй үгийн сангийн нэгж буюу адууны явдал тус бүрийг дотор нь хэрхэн ялган нэрлэсэн монгол сэтгэлгээний онцлогийг тайлбарлах болно.

2. Судалгааны арга зүй

Монгол ардын зүйр цэцэн үг, оньсогод зөвхөн адууны бие эрхтний онцлог, шинж төрх, зүс, байр байдал, явдал хөдөлгөөн, хүний амьдралд гүйцэтгэх үүрэг зориулалт зэргийг нь ажиглан мэдсэний үндсэн дээр бусад юм үзэгдэлтэй жишин, урнаар дүрсэлсэн нь элбэг байна. Тийм зүйр цэцэн үг 914, адууг оньсоголсон 73, адууны нэр бүхий 294 оньсого байгааг бид бүртгэн “Таван эрдэнэтэй монгол зүйр цэцэн үг” (Го.Гэрэлмаа, 2022), “Таван эрдэнэтэй монгол

оньсого” (Го.Гэрэлмаа, 2022) гэсэн хоёр бэсрэг түүвэр хэвлүүлсэн юм. Эдгээрээс өнгөн бүтцэд нь адууны явдлын талаар туссан зүйр цэцэн үг, оньсогог хэрэглэгдэхүүн болгон ашиглав.

Эрдэмтэн Д.Бадамдорж “Хэл шинжлэлд зүйлчилж сэдэвчилсэн үг хэллэгийг үгийн утгын орон гэдэг тул монгол хэлний үгийн сан, утга зүйн өвөрмөц судлагдахуун болсон үгийн утгын орныг тухайлан шинжлэх нь сургалт-эрдэм шинжилгээний ач холбогдолтой юм” (2023: 5) гэжээ. Тиймээс бид Дж.Лакофф, М.Жонсоны танихуйн зүйрлэл (cognitive/conceptual metaphor)-ийн онолд тулгуурлан, “аддууны явдал” гэсэн утгын орны хүрээнд монголчууд аддуугаа хэрхэн танин мэдэж, түүний явдлыг нэрлэхдээ бусад амьтан, юм үзэгдлийн шинж чанартай хэрхэн холбон сэтгэж, тодруулан чимсэн аргыг тодруулан авч үзэх болно.

3. Аддууны явдал заасан үгс

Монголчууд аддууныхаа хурд хүч, явдал гишгэдэл, зан араншны онцлогийг харгалзан үзэж, тэдгээрийг хүний нас, хүйс; улирал цаг уурын онцлог, замын хол, ойр, бартаа саад; уналга (өдөр тутмын, баяр ёслол, гоёлын), хөсөг зэрэг янз бүрийн зориулалтаар тус тус тохируулан сонгож, эдэлсээр иржээ. Иймээс ч аддуугаа илүү танин мэдэж, өнгө зүс, авир ааш, явдал гүйдлийг нь бусад малаас илүү олон янзаар ялган нэрлэж иржээ. Тухайлбал, Эрдэмтэн Б.Сумъяабаатарын “Гучин зургаат тайлбар толь” бичгийнхээ 31-р дэвтрийн “Морь малын явах зүйлд дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

Алхам – Хөл нэгэнт шилжихүйг гэн алхам хэмээмүй_(G-31-42a, T-4361)

Алхмуй – Нэгэн алхам, нэгэн алхмаар явахүйг алхмуй хэмээмүй_(G-31-42a, T-4361)

Алхам сайн – Морь, луусны хурдхан явахыг алхам сайн хэмээмүй_(G-31-42a, T-4362)

Алхдал их – Морь, малын өмнөх хөлийн гишгэсэн морийг хойд хөл өнгөрөн алхахүйг Алхдал их хэмээмүй_(G-31-42b, T-4362)

Сайвар – Морь, малын зэрэг мал, алхмаас хурдхан, жороогоос алгуурхнаар явахүйг Сайвар хэмээмүй_(G-31-42b, T-4362)

Жороо – Сайвраас хурдныг жороо хэмээмүй_(G-31-42b, T-4363)

Сүүл хөдөлгөн явмуй – Хатирхуйд баахан хүрэхгүй, хурдхан явахүйг сүүл хөдөлгөн явмуй хэмээмүй_(G-31-42b, T-4363)

Хатирмуй – Морь, луусын зэрэг мал алхамгүй дэндэлзэн явахүйг хатирмуй хэмээмүй_(G-31-42b, T-4364)

Шогшмуй – Морь хурдхан хатирхуйг шогшмуй хэмээмүй_(G-31-43a, T-4364)

Зөөлөн хатирмуй – Алхамгүй алгуур төвшин хатирхуйг зөөлөн хатирмуй хэмээмүй_(G-31-43a, T-4365)

Шуугъж – Морь унаж хурдан явуулхуйг шуугъж хэмээмүй. _(G-31-43a, T-4365)

Дурдхийж – Морины хурдан жороолох байдал. _(G-31-43a, T-4365)

Сэгэлгэмүй – Шогшихоос хурдан явуулхуйг сэгэлгэмүй хэмээмүй. _(G-31-43a, T-4366)

Нохойн сэгэлгэ – Нэгэнт нохойн адил сэгэлгэхүйг нохойн сэгэлгэ хэмээмүй

Ухасхиймүй – Морь хөдөлж довтолхуйг Ухасхиймүй хэмээмүй_(G-31-43a, T-4366)

Довтолмуй – Аливаа малын зэрэг юм хурдан хурдан харайхуйг довтолмуй хэмээмүй_(G-31-43a, T-4366)

Хийсгэн довтолмуй – Морийг ухасхийгүүлж шахардан довтолхуйг хийсгэн довтолмуй хэмээмүй_(G-31-43a, T-4367)

Давхимуй – Морийг шахардан ташуурдахуйг давхимуй хэмээмүй_(G-31-43a, T-4367) (2006: 16387-16413).

Харин адуу судлалын ухаанд адууны явдлыг дараах байдлаар тодорхойлжээ. Адууны явах хөдөлгөөн нь төв мэдрэлийн тогтолцооны удирдлага зохицуулалтаар хийгдэнэ. Адуу газрын гадаргуу, замын байдлаас шалтгаалж, толгой, хүзүү, хөл мөчнийхөө хөдөлгөөнөөр хүндийн төвөө тохируулж биеийн тэнцвэрээ сайн олдог онцлогтой. Адуу давших хөдөлгөөнөө хойд хөлийн түлхэлт, ууц, хондлойн булчингийн ажилтаар хийнэ. Адууны явдлыг алхааны урт, өндөр, нам, давтамж зэргээр нь ялгадаг. Алхмын уртыг урд хөлийн гишгэлтийн зайгаар тодорхойлдог. Хойд хөлийн тавилт урд хөлийн гишгэлтэд хүрэхгүй бол богино алхаатай, хэрэв

давж гишгээж байвал алхаа холтой гэж хэлнэ. Алхааны өндөр намыг хөлийн өргөлтийн хэмжээгээр тогтооно. Адууны явдлыг **гэлдэргээ, хатир, жороо, давхиа** гэж ангилдаг (Хишигбат 2000: 65) гэжээ.

Мал аж ахуйн шинжлэх ухаанд адууны явдлуудыг хэрхэн нэрлэн тэмдэглэснийг ардын зүйр цэцэн үг, оньсогод тусгасан адууны явдалтай харьцуулан тайлбарлавал:

3.1. Гэлдэргээ

Эрдэмтэн А.С.Красников “Гэлдэргээ нь давших хөдөлгөөний үндсэн төрөл юм. Адууг гэлдрэн явах үед 4 хөлөөрөө газар цохих чимээ дараалан сонсогдоно. Гэлдрэх үед адуу буруу талын урд хөлөө урагш зөөхийн хамт тэр даруйд зөв талын хойд хөлөө зөөж тавиад дараа нь зөв талын урд хөлөө урагш зөөхийн хамт буруу талын хойд хөлөө урагш зөөх зэргээр хөдөлгөөн хийнэ” гэжээ. Харин эрдэмтэн Хашбат (2000) “Жирийн алхан гэлдрэх үед адууны хойд хөл нь урд хөлийн мөр дээр гишгэдэг. Гэлдэргээний үед алхмын хэмжээ нь 0,8-1,2 м, давтамж нь минутад 100 удаа, хурд нь 1,5-2,0 м/сек, цагт 4-5 км замыг туулдаг. Харин хөнгөн хэвилийн уналгын адуу цагт 6-8 км зай туулна” (1973: 66) гэж тодорхойлсон байна. **Гэлдэргээ** гэдэг нь гэлдрэх гэсэн үйл үгийн нэршүүлсэн хэлбэр бөгөөд энэ үгийн утгыг эрдэмтэн Я.Цэвэл “**гэлдрэх** – маш алгуур аажмаар алхан явах; **мориор гэлдрэн явах**” (2013: 234) гэж тайлбарлажээ. Ер нь монголчууд алив хүн, малыг “гэлдэрч явна” гэвэл толь бичигт тайлбарласанчлан ойлгох болно. Харин адуу судлалд “гэлдэргээ” хэмээх явдлаар адуу цагт 4-8 км замыг туулдаг гэж тайлбарласнаар бол энэ нэр томьёо нь дээрх “Гучин зургаатын тайлбар толь”-д буй **алхах, алхам сайн, алхдал их** гэсэн үгтэй утга дүйх юм.

Адууны алхааг монгол ардын аман зохиолд:

Сайн эр санаандаа

Сайн морь алхаандаа

Аавын хүү алцан алцан алхана

Адууны хүү **гүдэн гүдэн алхана** гэж дүрсэлжээ. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс хэвлүүлсэн “Монгол хэлний их тайлбар толь”-д “**гүдэн- гүдгэр, товгор газар**” (МХДТТ., 2008: 562) гэж, харин Ш.Одонтор, Ш.Баттөгс нар “**гүдэн – овгор товгор гадартай, овон товон**” (2013: 200) гэж тайлбарлажээ. Үүнээс харахад “гүдэн гүдэн алхах” гэдэг нь толгой бага зэрэг унжуу, нуруу гүдгэрдүү маягтай, хол хол зайтай нэгэн хэмээр алхахыг ялган тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл адууны явдлыг биеийн галбир төрхөөр нь тодотгон нэрлэсэн байна.

Мөн зүйр цэцэн үгэнд:

Тэгэр тэгэр алхсан морь

Тэр газартаа хүрдэггүй

Тэгнэ тэгнэ гэсэн хүн

Тэр үгэндээ хүрдэггүй гэжээ. Толь бичгээс хайхад “тэгэр” гэсэн үг олдсонгүй. Харин “**тэгэрэг** – унгас бөөлжүүлж хийсэн дугуй оройтой малгай, **тэгэрэг** – 1.хавтгай дугуй, 2.дугуй оройтой унгасан малгай” гэж, харин “**дэгэр – дэгэр хийх** – 1.дэггэр юмны хөдлөх, 2.дэгцэн дэглэгнэн хөдлөх /дэгэр дэгэр цогих-үсэрхийлэн цогих/, **дэгэргэн** – дэгэн догон, тэгш бус, тогтворгүй хөдөлгөөнтэй: **дэгэргэн жороо-халбилзсан жороо**” (Болд нар, 2008: 796) гэж тайлбарлажээ.

Монгол бичигт d, t гийгүүлэгч авиаг үгийн эхэнд ижил дүрсээр тэмдэглэж, нутгийн аялгуунд энэ хоёр авиа (d~t) сэлгэдэг. Тиймээс “тэгэр ~ дэгэр” гэж авиа суларсан байж болох тул дээрх зүйр үгэнд “дэгэр дэгэр алхсан морь хол явдаггүй” гэсэн санааг гаргахдаа адууны явдлыг хөдөлгөөний дүр байдлаар нь тодчилсон гэж үзэж болох юм.

Мөн зүйр үгэнд:

За за гэсэн хүн хийх нь хол

Завар завар гэсэн морь хүрэх нь хол

Жиг жиг гэсэн хүн үгэндээ хүрдэггүй

Зэгэр зэгэр гэсэн морь өдөртөө хүрдэггүй гэжээ. Толь бичигт “*завар* – чадамгай, *зэгэх* – урьтаж түрүүлэх” (Болд нар, 2008: 796, 938) гэж тайлбарлажээ. Үүнээс харахад бусдаас түрүүлэн дүүлж давхидаг, омголон омтгой явдалтай адуу төдийлөн хол замыг туулж чаддаггүй болохыг ийнхүү хөдөлгөөний шинжээр нь тодотгон дүрсэлжээ.

3.2. Хатир

“Энэ нь адууны хурдан явдал юм. Дөрвөн хөлийн чимээ сонсогдох бус буруу өрөөлийн хос хөлийн чимээ сонсогдоно. Баруун талын урд хөл ба зөв талын хойд хөлийг зөв талын урд хөл ба буруу талын хойд хөлтэй ээлжлэн зөөж тавих явдал юм. Ийм маягаар хөлөө ээлжлүүлэн зөөж тулахынхаа хооронд хоромхон зуур газраас хөндийрдөг. Адуу ердийн хатирааны үед 9-10 км/ц, дунд зэргийн хөнгөн хатираа 11-13 км/ц, хурдан хатирааны үед 14-15 км/ц, дээд зэргийн хурдан хатираа 30км/ц хурдална (Хашбат, 2000: 69).

Хамгийн хол замыг ядралгүй хурдан туулдаг морийг хатир сайт морь гэдэг. Зүйр цэцэн үгэнд:

Хатирч морины хавирга нойтон,

Хараалч эмийн хошуу нойтон

Өдөртөө хатирах морь

Үгэндээ хүрэх залуу гэдэг. Монгол хэмжээсэнд *өдрийн газар* гэж адууны ердийн явдлаар багцаалж, ойролцоогоор 90-100 км зайг хэлнэ. Хатирч морь ийм зайг ажралгүй өдөртөө туулдаг. Мөн оньсогод:

Жирийтэл хатирч

Жингэнэтэл янцаана /голио/ гэжээ. Эрдэмтэн Я.Цэвэл “*жирийх-1.юмны жиргээр болж үзэгдэх, 2.гуйх, хурдлах*” (2013: 347) гэж тайлбарлажээ. Хэдийгээр энэхүү оньсогын гүн бүтцэд голионы тухай өгүүлж буй боловч өнгөн бүтцэд голионы явдлыг адууны явдлаар төлөөлөн илэрхийлж байна. Мэдээж голио, адуу хоёрын явдлыг харьцуулах аргагүй юм. Үүнийг ийнхүү зүйрлэсний учир нь энэ хоёр амьтны хурдлах үед хөл нь жирэлзэн харагдах байдал нь хүний танин мэдэхүйд ижил шинжийн аналогийг үүсгэж буйтай холбоотой.

Оньсогод:

Хар морь хайван хатирна

Хазааргүй жийгэн хатирна /голын ус/ гэж дүрсэлжээ. Эрдэмтэн Я.Цэвэл “*хайвах* – 1.зүүн, баруун тийш дайвах, гуйвах, 2.шувуу ба малын усчлан явах; *жийгэх* – хурдлах” (2013: 885) гэж тайлбарлажээ. Тэгэхээр “хайван хатирна, жийгэн хатирна” гэдэг нь зүүн, баруун тийш ялимгүй дайвалзан хурдан явах, эсвэл усан дундуур давхихыг хэлнэ. Энд голын урсгалыг далд утгаар буюу адил төстэй зүйлтэй зүйрлэн илэрхийлэхдээ морины явдлын жигд эрчимтэй үйл хөдлөлийн дүр байдлаар нь тодчилон оньсого бүтээжээ.

Адуу явах үед гарах дуу чимээг мэдэрч, улмаар адууны явдлыг авиа дуурайх үгээр тодчилон нэрлэсэн жишээ бас байна. Тухайлбал, эрдэмтэн Б.Сумъяабаатар “*хур* - үргэдэг морины хамрын дуун, *хур хур* – довтолсон морины сүйлхийлэн хамраар амьсгал авах дуун, *фос фос* – морины хөл бүдэрхийлэх чимээ, *хар хур* – морь, мал чулуутай газарт явах байдал” (2006: 290) гэж тайлбарлажээ. Харин оньсогод:

Тов тов хатираад

Торгон тээгээ гээнэ /морь баах/

Бур бур хатираад

Булган малгайгаа гээнэ”/адуу баах/ гэж адууны явдлыг дуу авиа дуурайх үгээр чимэн илэрхийлжээ.

Үүнээс гадна адууны явдлаар ёгтлон ахуй хэрэглээний аж байдлыг оньсоголсон жишээ цөөнгүй. Тухайлбал,

Буурал морь бусган бусган хатирна

Булт олон өнгийн өнгийн харна /хоол буцлах/ гэж оньсогын өнгөн бүтцэд адууны үргэн, огцом зайлах хөдөлгөөнөөр нь түүний явдлыг тодчилсон байна.

Шогших гэж морь хурдан хатирахыг хэлдэг боловч энэ нэрлэлтийг адуу судлалд хэрэглэдэггүй ажээ. Харин зүйр цэцэн үгэнд:

Муу морины шогших нь нидрэх шиг

Муу эрийн гүйх нь гэлдрэх шиг хэмээн дүрсэлсэн байна. Энд адууны явдлыг түүний чадал тэнхээгээр тодотгон дүрсэлжээ.

3.3. Жороо

“Адууны хамгийн уран явдал юм. Жороолох үед адуу нохой өрөөл /диагональ/ байдлаар тулдаггүй, зөв талын урд, хойд, буруу талын урд, хойд хөлийг зэрэг шилжүүлэх хөдөлгөөн хийнэ. Жороолох явдлын хөдөлгөөний хэв маяг, хурд, алхмын зай зэргээс шалтгаалж дотроо хэд хэдэн янз байдаг. Жороо морийг ихэвчлэн найр наадамд унадаг бөгөөд явдлын хурд, ур хийцээр нь хонин жороо, дүүрэн жороо, усан тэлмэн жороо гэх мэтээр ялгагддаг. Зарим адуу төрөлхийн жороо байхад зарим нь төрмөл бус унаж буй хүний сургаснаар жороо, сайвар явдлыг хольж гишгэх нь бий. Жороо адууны явдлаар энгийн алхаж явахыг алхаатай адуу гэнэ. Үүний зэрэгцээ арилжаа, сайвар зэрэг уран алхаатай явдлууд бас байдаг” (Хашбат, 2000: 69).

Монголын жороо морины холбооны ерөнхийлөгч, адуу судлаач Д.Эрдэнэхуяг “Тод магнай” сэтгүүлд өгсөн ярилцлагадаа “Адууны сурсан явдлыг ‘пассаж’ гэж нэрлэдэг. Энэ нь францын ‘нэвтрэх, гарах’ гэсэн үгээс гаралтай. Үүнийг монголчууд ‘ормол жороо’ гэдэг. Монголчууд эртнээс адуунд жороо явдал сургаж баяр наадам, гоёлын унаанд эдэлж ирсэн уламжлалтай. Адууны жороолох явдлын хамгийн бага аажим хэмнэлийг ‘сайвар’ гэж ялгадаг. Сайвар явдал нь маш эвтэй, зөөлөн тул ихэс дээдэс болон эмэгтэйчүүд унах нь элбэг. Адууны жороо явдлыг түгээмэл нэрлэх ялгаанд:

а. Унаган жороо: Эхээс төрмөгцөө жороолж, даага үрээ насандаа ч уг явдлаа алдахгүй сулдаа жороолохыг хэлнэ.

б. Усан тэлмэн жороо: Дөрвөн хөлийн тавилт тэгш нэгэн хэмээр эрч хурдтай, усны урсгалыг санагдуулам жороолохыг хэлнэ.

в. Хонин жороо: Хонины явдалтай адил зөөлөн жороолох ба тэгш хэмтэй, хурд таарууг хэлнэ.

г. Тэмээн жороо: Тэмээ тэших адил сэгчээ ихтэй, хурдан жороо морийг ийн нэрлэнэ.

д. Дээгүүр жороо: Хөлөө зөөх зайг илүүтэй /суга, цавиа сайн тэнийлгэн/ тавьж жороолохыг дээрээс авч байна гэх буюу дээгүүр жороо гэнэ.

е. Доогуур жороо: Ергөө буюу жирийн хатираас хэтрэхгүй хурдтай жороолохыг доогуур жороо гэх буюу зарим нутагт сайвар явдал ч гэж хэлдэг” (Эрдэнэхуяг, 2012-11-20) гэжээ.

Зүйр цэцэн үгэнд

Хүн хүний санаа адилгүй

Хүлэг морины жороо ижилгүй гэдэг. Энэ нь эртнээс морины жороо явдлыг дотор нь олон янзаар ялгадаг байсны гэрч юм. Тиймээс монгол ардын зүйр цэцэн үг, оньсогод адууны явдал заасан үгээс хамгийн олон давтамжтай нь *жороо* гэсэн үг (50 орчим) байна. Тухайлбал:

Унаган жороо төрөх гэдэг

Унах хүний хувь мэднэ гэж насаар нь явдлыг нь тодчилон нэрлэжээ.

Мөн

Жороо гүүнээс

Сайвар унага гэснээр адууны явдал удамшдаг, угшил гарвал нэгтэйг илтгэжээ.

Гэтэл

Гүйм жороо морь ч

Гүүний умайгаас гарна

Гүрэн төрийн эзэн ч

Эхийн умайгаас төрнө гэсэн зүйр үгэнд адууны явдлыг хурдаар нь тодруулан чимж нэрлэжээ. Харин оньсогод

Хээр морь хэвэн жороо

Хивс тохон налим жороо

Ойр хүн суум жороо

Хол хүн зогсом жороо /хуур хуурдах/ гэсэн оньсогод хүний хэрэглээний эд зүйлийн шинж чанараар зузаан хивс тохом ч намирмаар, түүнийг ойроос харсан хүн суусан чигээрээ, холоос харсан хүн босон зогсож алмайрмаар гэсэн хэтрүүлэл хэрэглэж, жороо морины явдалд хандах өгүүлэгчийн сэтгэлийн өнгө аясаар тухайн морины явдлыг тодчилсон байна.

3.4. Давхиа

Энэ нь хамгийн их хурдан, хүч шавхсан явдал юм. Адууны давхих үед туурай нь газарт бууж байгаа дараалсан гурван чимээ сонсогдоно. Тухайлбал, буруу талын хойд хөлөөр түлж дараа нь буруу талын урд хөл ба зөв талын хойд хөл дээр тулах, дараа нь зөв талын урд хөл дээр тулах бөгөөд түлхэлт хийн үсэрч газраас хөндийрөөд буухдаа эхлээд буруу талын хойд хөл дээрээ тулах зэргээр дараална. Давхих явдлыг энгийн, дунд зэргийн, дээд зэргийн хурдаар давхих гэж ялгадаг. Дунд зэргийн хурдтай давхилт цагт 30-40 км, дээд зэргийн давхилт цагт 60 км замыг туулна. Алхмын зай 1,5-2 м ба 6 м хүртэл байна (Хашбат, 2000: 66-70).

Зүйр цэцэн үгэнд:

Хүн ухааныхаа хэрээр хийдэг

Хүлэг чадлынхаа хэрээр давхидаг гэснээс харахад адууны хамгийн хурдан явдал нь давхих ажээ. Харин

Өдөртөө давхисан морь эзэндээ янаг

Үгэндээ хүрсэн хүн нөхөртөө янаг гэсэн үгээс холч давхиатай морь хэчнээн өндөр үнэлэмжтэй болох нь харагдаж байна. Мөн

Талын адуу таргиж тургиад давхичихна

Тарган бор азарга нь цогъж ядаад хоцорно /царцаа голио/ гэсэн оньсогод дуу авиа, хөдөлгөөний зүйрлэлээр адууны өмнөд хоёр хөл зэргээр, хойд хоёр хөл зэргээр ээлжлэн харайлан хурдан явах явдлыг харагдаж, сонсогдтол сонирхолтой дүрсэлжээ.

Адуу судлалд “**довтлох**” гэсэн хэллэгийг хэрэглэдэггүй боловч “дээд зэргийн давхилт” гэж тодорхойлсон байна. “Гучин зургаатын тайлбар толь”-д “**Довтолмуй** – Аливаа малын зэрэг юм хурдан хурдан харайхуйг Довтолмуй хэмээмүй” (Сумьяабаатар, 2006: 16409) гэж тайлбарлажээ. Оньсогод:

Довтолж явахдаа

Товчоо гээх” /морь баах/ гэж байна.

Мөн адуу судлаач Ш.Хашбат харайх нь адууны давших хөдөлгөөний нэг мөн (2000:71) гэж дурдсан ч адууны явдлын төрөлд тухайлан оруулаагүй байна. Харин зүйр цэцэн үгэнд:

Залуу морь харайдаг

Зан муут эрхэлдэг гэж, харин оньсогод:

Зээрд морь зэвэргэн харайв

Шинэхэн гөлмөө чирэн харайв /түймэр, цурам/ хэмээсэн байна.

Монголчууд адуу нутгаа мөрөөдөн зорин явахыг адуу гүйх гэдгээс гадна хурдан гэсэн утгыг ч мөн гүйх гэсэн үгээр илэрхийлдэг байна. Тухайлбал,

Гүн бодлоготныг явдлаас нь тань

Гүйх морийг сойлгоос нь тань

Хар морь гүйвэл хазаартаа тултал

Хангайн адуу үргэвэл хэмжээндээ хүртэл /од харвах, үүл нүүх/

Жир жир гүйдэлтэй

Жингэр жингэр дуутай

Жаран хүн дагуултай /морины явдал, сүүл/

Шувтан хөх морь

Шур шур гүйдэлтэй /урсгал ус/

Шур шур гүйдэлтэй

Шулуун хөх морьтой

Таахай гуталтай, таван хүн дагуултай” /юм оёх/


Ноён суудалтай

Нохой гүйдэлтэй” /морьтой хүн/ гэх мэт жишээнд адилтгал, зүйрлэл, ёгтлол, эсрэгцүүлэл зэрэг уран дүрслэлийн аргыг хэрэглэжээ.

4. Судалгааны үр дүн

Адууны явдлыг шинжлэх ухааны талаас болон ардын зүйр цэцэн үг, оньсогын өнгөн бүтцэд хэрхэн ялган нэрлэснийг тоймлон харуулбал:

4.1. Адуу судлалд:



Бүдүүвч 1. Адууны явдал

4.2. Ардын аман зохиолд:

1. **Алхах** (тэгэр тэгэр алхах, гүдэн гүдэн алхах, зэгэр зэгэр алхах, завар завар хийх),
2. **Шогших**
3. **Хатирах** (бур бур хатирах, хайван хатирах, жийгэн хатирах, жирийтэл хатирах, бусган бусган хатирах, тов тов хатирах),
4. **Жороолох** (гүйм жороо, сайвар жороо, унаган жороо, хээвэн жороо, хэвэлзэх, хүр хүр жороолох, бор бор жороолох, налим жороо, суум жороо, зогсом жороо),
5. **Давхих** (жийгүүлэх),
6. **Довтлох**
7. **Харайх** (зэвэргэн харайх),
8. **Ухасхийх** (бурдхийх, жир хийх, нор хийх, тас няс хийх),
9. **Гүйх** (жир жир гүйдэл, шур шур гүйдэл),
10. **Явах** (шур шур явах, түгдэр түгдэр явах),
11. **Цогих**

Үүнээс гадна адууны зан араншны хамаарлаар нь дүрсэлсэн **хашигнах, шарвах, ийлэх, хадуурах, хулжих, цойлох** гэх мэт үг хэллэг бий. Мөн хурдан морийг ардын аман зохиолд **чоно гүйцэх морь, алс газрыг товчлогч эвэр далавчит гуа тогос, эрчилж**

цойлж явдаг хурц сумын хурдтай, хурдан харцага, нисэх шувуу гэх мэтээр бусад амьтан, юмстай адилтгаж уран дүрсэлсэн байдаг.

Эдгээрээс харахад монголчууд дээр үеэс цаг уурын хатуу ширүүн нөхцөлтэй жилийн дөрвөн улиралд бүс нутгийн бэлчээр, уул усны онцлогтоо зохицуулан эрдэнэт адуун сүргээ адуулан маллах явцдаа түүнийг таньж мэдсэн мэдлэгээ үндэсний хэл соёлын томоохон өв болгон аж амьдрал, хэл соёлдоо шингээн хадгалж, уламжилсаар ирсэн ажээ.

Адуу судлалын ухаанд нэр томьёоны шинжтэй, адууны явдлыг нэрлэсэн үгс харьцангуй цөөн, утга илтгэх чадамжаар ядуухан байхад ардын аман зохиолын оньсого, зүйр цэцэн үгийн өнгөн бүтцэд харьцангуй баялаг, өргөн дэлгэр тохиолдож буйг онцлон тэмдэглүүштэй.

5. Дүгнэлт

Бид зөвхөн ардын зүйр цэцэн үг, оньсогын өнгөн бүтцээс ажиглахад адууны үндсэн явдлыг ерөнхийд нь 11 ангилж, тэдгээрийг дотор нь 50 гаруй янзаар дүрслэн ялгаж, адууны явдлыг нэрийдсэн утгын орныг үүсгэж болж байна. Үүнээс адууны явдлыг тодруулан чимсэн аргыг утгын ангиллаар нь харвал:

1. Гадаад төрх галбир заасан үгээр (*гүдэн гүдэн алхах*)
2. Дүр байдал дуурайх үгээр (*тэгэр тэгэр хийх*)
3. Шинж заасан үгээр (*завар завар хийх*)
4. Үйл хөдөлгөөн заасан үгээр (*жирийтэл хатирах, хайван хатирах, гүйм жороо, налим жороо*)
5. Дуу авиа дуурайх үгээр (*бур бур хатирах, тов тов хатирах, шур шур гүйдэлтэй, тас няс хийх*)
6. Нас заасан үгээр (*унаган жороо*)
7. Зан араншныг заасан үгээр (*бусган бусган хатирах*)
8. Угшил, удамшил заасан үгээр (*жороо гүүнээс сайвар унага*)
9. Чадал тэнхээ, хурд хүч заасан үгээр (*муу морины хатирах нь нидрэх шиг*)
10. Амьтны нэрээр (*нохой гүйдэл*)
11. Өгүүлэгчийн сэтгэлийн хөдлөл заасан үгээр (*суум жороо, зогсом жороо*) гэх мэт.
12. Эд зүйлсийн хөдөлгөөн заасан үгс (*хивс тохом налим /намирам/ жороо*) гэх мэтээр илэрхийлжээ.

Өөрөөр хэлбэл нүүдэлчин монголчууд адууныхаа явдлыг дүрслэхдээ түүний биеийн галбир, хөдөлгөөний эрчим, нас, гарал угшил, зан араншин, чадал тэнхээ зэрэгтэй холбон сэтгэхээс гадна бусад юм үзэгдэл, амьтны дүр байдал, дуу чимээ; тухайн үзэгдлийг ажиглагч хүний сэтгэлийн өнгө аяс зэрэгтэй холбон сэтгэж, зүйрлэн нэрлэдэг үндэсний сэтгэлгээний өвөрмөц онцлог байна.

Ингэж нүүдлийн мал аж ахуйн хөгжлийн явцад малчин хүний танин мэдэхүйн нарийн мэдрэмж, ажигч гярхай байдлын үр дүнд монгол хэлний үгийн санд таван хошуу малын нас хүйс, өнгө зүс, авир араншин, үйл хөдөлгөөн зэргийг нэрийдсэн зүйлчилсэн үг хэллэгийн олон олон утгын орон бий болж, улмаар эдгээр үг хэллэг нь монгол үндэсний сэтгэлгээний онцлогийг хадгалсан сүегэр нэгжүүд үүсэхийн эш үндэс болдог ажээ.

Таван хошуу малын шинж, үйл хөдөлгөөн заасан үг хэллэгийн утгын орныг аль болох бүрэн илрүүлэх үүднээс ардын аман зохиолын бүх төрөл зүйл, уран зохиолын арвин баялаг сангийн хүрээнд дэлгэрүүлэн судлууштай.

Ном зүй:

А. Монгол хэлээр:

- Бадамдорж, Д.** (2023). *Монгол хэлний утга зүйн судалгаа, II боть*. Улаанбаатар: МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн. [Badamdorj, D. *Mongol khelnii utga züin sudalгаа II boti* [Semantic Studies of the Mongolian Language, Volume II]. Ulaanbaatar: Institute for Mongolian Studies. 2023.]
- Зэнямбуу, Ч., Базаррагчаа, М.** (2014). *Монгол хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь*. Улаанбаатар: Бит Пресс. [Zeenyambu, Ch., Bazarragchaa, M. *Mongol khel jinfleliin ner tomionь tailbar toli bichig* [Glossary of Mongolian Linguistic Terms] Ulaanbaatar: Bit Press. 2014.]
- Мөнхтөр, Л.** (2002). *Монгол адууны зүс, шинж заасан үгсийн утгазүй, бүтэц*. Улаанбаатар: Тоонот принт. [Mongol aduuny züs, shinj zaasan ügsiin utgazүй, бүтэц. [The semantics and structure of words which is related to describe the color and characteristics of Mongolian horses.] Ulaanbaatar: Toonot Print. 2002.]
- Одонтор, Ш., Баттөгс, М.** (2013). *Монгол хэлний гучтын тайлбар толь*. Улаанбаатар: Цагаан бамбарууш. [Odontör, Sh., Battögs, M. *Mongol khelnii guchtyн tailbar toli* [The Mongolian Explanatory Dictionary in 30 volumes] Ulaanbaatar: Tsagaan bambaruush. 2013.]
- Сумьяабаатар, Б.** (2006). *Гучин зургаат тайлбар толь-VIII*, Улаанбаатар: Жинст Харгана принт. [Sumiyabaatar, B. *Guchin zurgaat tailbar toli-VIII* [The Mongolian Explanatory Dictionary in 36 volumes] Ulaanbaatar: Khargana Print. 2002.]
- Хашбат, Ш.** (2000). *Адуу судлал*, Улаанбаатар: Мөнхийн үсэг. [Khashbat, Sh. *Aduu судлал* [Equine science] Ulaanbaatar: : Mönkhiin üseg. 2006.]
- Цэвэл, Я.** (2013). *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар: Мөнхийн үсэг. [Tsevel, Ya. *Mongol khelnii towch tailbar toli* [Concise dictionary of the Mongolian language] Ulaanbaatar: Mönkhiin üseg. 2013.]
- МХДТТ.** (2008). ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн. Эрхлэн хэвлүүлсэн Л.Болд. *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь*. Улаанбаатар: Бемби сан. [Bold, L. *Mongol khelnii delgerengүй tailbar toli* [Comprehensive dictionary of the Mongolian language] Ulaanbaatar: Bembi san. 2008.]

Б. Гадаад хэлээр:

- Красников, А.С.** (1973). *Коневодство*, Москва. [Krasnikov, A.S. *Konevodstvo* [Equine science] Moscow. 1973.]